

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, Пүрэв гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-6
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	7-17
<hr/>	
1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	7-8
2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	8
3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	9-17

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 12-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 30 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батбаяр, Г.Ганбаатар, П.Сайнзориг, Б.Заяабал, Д.Пүрэвдаваа.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Тэгшжаргал нар байлцав.

Танилцуулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

***Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн эцсийн хувилбартай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д заасан залруулга гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 09 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Тэгшжаргал нар байлцав.

Ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Хоёр. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Ц.Даваасүрэн:** Төсөлд дараах агуулгатай 4 дүгээр зүйл шинээр нэмэх:

Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т заалгасугай:

1/2026 оны төсвийн жилээс эхлэн Боловсролын салбарын төсвийн нийт зардлыг ДНБ-ий 6 хувиас багагүй эсвэл Улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж өргөн барих.

2/Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх гэсэн саналаар дахин санал хураалт явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 4

Бүгд: 18

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Баясгалан нарыг дэмжсэнээр тооцож, 88.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төсөлд дараах агуулгатай 4 дүгээр зүйл шинээр нэмэх:

Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга

хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т заалгасугай:

1/2026 оны төсвийн жилээс эхлэн Боловсролын салбарын төсвийн нийт зардлыг ДНБ-ий 6 хувиас багагүй эсвэл Улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж өргөн барих.

2/Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 16  
Бүгд: 18  
11.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

### **3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Ц.Даваасүрэн:** Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3/2025 оны Улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож, магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтааж Улсын Их Хуралд танилцуулах гэсэн саналаар дахин санал хураалт явуулья гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 4  
Бүгд: 18  
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3/2025 оны Улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож, магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтааж Улсын Их Хуралд танилцуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 18  
Бүгд: 18  
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.*

**Хоёр.** “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Г.Дамдинням нарын гаргасан, 7/Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалтын шаардлага хангасан барилгыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс “лизингийн нөхцөлөөр өөрийн өмчлөлд бүрэн шилжүүлж авах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 7  
Бүгд: 19  
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Мөнхсоёл, Ж.Баясгалан, Д.Батлут, П.Ганзориг нарыг дэмжсэнээр тооцож, 89.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 44 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 14 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ  
ЧУУЛГАНЫ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН  
12-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Даваасүрэн:** Гишүүд 13 гишүүн болж байна. Хуралдаанаа эхэлнэ ээ. Бүртгүүлчих. Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье ээ. Байнгын хорооны хуралд ирсэн гишүүдийг би та бүхэнд танилцуулъя. Тилеуханы Аубакир, Дамбын Батлут, Хөххүүгийн Болормаа, Гонгорын Дамдинням, Даваагийн Цогтбаатар, Рэнцэндоржийн Батболд, Батмөнхийн Батцэцэг, Хассуурийн Ганхуяг, Баатаржавын Мөнхсоёл, Жигжидийн Батжаргал, Жадамбаагийн Баясгалан, Цэрэнпилийн Даваасүрэн, Пүрэвбаатарын Мөнхтулга гэсэн гишүүд бүртгүүлсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны хуралдааны ирц 25 гишүүнээс 13 гишүүн ирж, 52 хувьтай байгаа учраас 2024 оны 12 сарын 12-ны өдрийн хуралдааныг эхлүүлье ээ.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-2027 оны төсвийн төсөөлөл энэ тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг.

2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлэг.

3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг гэсэн ийм 3 асуудал байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай хол холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна аа. Эхний асуудалдаа оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би та бүхэнд танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.



Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийн хувилбарыг та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбартай холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар гишүүн танилцуулъя. Баясаа дараагийнхыг нь дагаж байгаа хуулиудыг.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

09.33 цагт

Хоёр дахь асуудалдаа оръё. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг эхлүүлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүний миний танилцуулснаар байгаа юм байна.

Нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төслүүдэд нэмж тусгах эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Эцсийн хувилбартай холбогдуулаад асуух асуулттай гишүүн алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулга хийх саналтай гишүүн байна уу?

Алга байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг миний бие өөрөө танилцуулчихъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

09.35 цагт

Гуравдугаар асуудалд оръё. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье ээ.

Ажлын хэсэгт өөрчлөлт орсон байна. Болдын Жавхлан Сангийн сайд, Баярсайханы Солонгоо ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга, Доржсүрэн Хорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Эрдэмийн Төрбат ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 хууль, Улсын Их Хурлын 4 тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай Засгийн газрын тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачилж буцаах санал дэмжигдсэн. Иймд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 6 хуулийн төсөл болон Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, Засгийн газарт чиглэл өгөх тухай, Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 4 тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг хууль, тогтоолын төслүүдэд нэмж тусган төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбарыг та бүхэнд тараасан. Хууль тогтоолын төслүүдийн эцсийн хувилбарын төслүүдтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Байна, нэрээ өгчихье.

Ганхуяг, Батжаргал гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүн асуултаа асууна.

**Х.Ганхуяг:** Энэ тогтоолын төсөлтэй холбоотойгоор бид нар яах вэ нэг 2, 3 санаанууд оруулсан байгаа юм энэ төрийн өмчийн компаниудтай холбоотойгоор өглөг, авлагын тэр тооцоолол тооцоог нь хийлгэх хоорондоо тэр зээл өгдөг асуудлыг хязгаарлах гэх мэт. Энэ дээр сая хэлэлцүүлгийн явцад 2, 3 сэдэвтэй холбоотойгоор нэлээн маргаан гэх юм уу өрнөсөн. Тэр нь юу вэ гэхээр энэ төрийн албан хаагчдын тоотой холбоотой. Манай салбарын төрийн албан хаагчийг орон тоонд тэд дутаад байна, хэд дутаад байна гээд ямар ч нөгөө үндэслэх юм байхгүй байгаад байна.

Тэгэхээр энэнтэй холбоотой бид нар уг нь Төрийн албаны зөвлөл байх юм уу эсвэл Засгийн газарт байх юм уу. Яг энэ зохистой харьцаа тааз энэ тэр дээр уг нь чиглэл өгмөөр байгаа юм. Тэгээд яах вэ бид нар одоо ингээд данс хооронд нь мөнгө шилжүүлэх асуудал уг нь хуулиар хориотой байдаг. Тэгээд энийг сая бид нар Аудитын хуультай холбоотойгоор, дүгнэлттэй холбоотойгоор тэр Зөрчлийн, Эрүүгийн хуульд энэ өөрчлөлтүүдээ оруул гэдэг юуг бол оруулчихсан байгаа. Гэхдээ энэ тэр зохистой харьцаа эд нараа оруулж ирэхгүй бол энэ чинь нөгөө жил болгон тэдэн мянгаар нэмнэ, эдэн мянгаар нэмнэ гээд хүмүүсийн тоо оруулж ирээд байдаг. Гэхдээ тэр нь яг тэр нөгөө нийгмийн үйлчилгээний салбарт үнэхээр дутаад

байгаа юм уу, дутахгүй байгаа юм уу гэдгийг бид нар энд Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн явцад зүгээр судалгаагүйгээр л шийдвэр гарчхаад байгаа байхгүй юу.

Тэгээд тэр тал дээр дуугардаг ч хүн байдаггүй. Тэгээд өнөөдөр чинь 237 мянган төрийн албан хаагчтай болчихсон явж байна. Энэ дээр нэг бодитой судалгаа хийдэг, зохистой харьцааг нь гаргадаг нэг ийм асуудал ерөөсөө байхгүй байгаад байна шүү. Тэгээд Үндэсний хороо гээд л 44 Үндэсний хороо яриад байгаа юм. Мөн энэ дээр бас ялгаа байхгүй тэр нэг яг тэр үйл ажиллагаагаар нь нэгтгэх юм уу, тэр үйл ажиллагаагаа нэгтгээд нэгдсэн нэг төсөв тааз тавиад үйл ажиллагааных нь зардлаар энэ чиглэлээр Засгийн газар өөрөө хуралдаанаараа, тогтоолоороо зарцуулах эрхийг нь өгөхгүй бол бид нар тэндээ суучхаад тэр сайдад нь дуртай дургүйгээсээ ч юм уу юмаа тайлбарлаж чадаж байгаа, чадахгүйгээс нь болоод дүгнэлт хийгээд яваад байгаа нь бас зохисгүй байгаа юм.

Нэг ёсондоо Засгийн газар нь бид нар нөгөө гар хөл нь өвдчихөж байгаа байхгүй юу. Юм хийе гэгчхээд хийлгэхгүй байгаад байгаа юм.

3 дугаар асуудал энэ төрийн өмчийн компаниудтай холбоотой асуудал байгаа. 137 компани дээр 60 мянган хүн ажиллаж байна. Тэгээд орон нутгийн өмчийн компаниудыг харахад бас мөн 50-аас 60 мянган хүн ажиллаж байна. Ингээд төрийн албатайгаа нийлэх юм бол бараг 320, 330 мянган хүн болчихсон байна. Алдагдалтай ажиллаж байсан ч тэнд ингээд хэдэн мянган хүн ажиллаад байдаг, 60 мянган хүн, 137 компани гээд нэг компани дээр ойролцоогоор 4-өөс 50 мянган хүн ажиллаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээрээ нэг дүгнэлтээ хийдэг болмоор байна. Алдагдалтай ажиллаж байвал тэр орон тоог нь цомхотгох асуудлыг явахгүй бол тэр олон хүнийг чинь ингээд ажиллуулаад байхаар цалингийн зардал нь байнга.

**Ц.Даваасүрэн:** Ажлын хэсэгт орсон гишүүд л саналаа хэлж байна шүү дээ. Ер нь яах вэ зүгээр албан тасалгааны цонхоор хараад гэдэг шиг бид нар энчээнээс энэ хэмнэлтийг хийх, энэ таналт хасалтыг хийх гэдэг бол бас яг цаанаа бодит ямар үр дагавар авчрах вэ гэдгийг бол бас нарийн тооцож чадахгүй байгаа шүү. Яг энэ төрийн албан хаагчдын тоо, хүн амын өсөлт, хүүхдийн өсөлт, тэрэнтэйгээ уялдаад эмнэлэг, сургууль шинээр баригдаад ингээд орон тоонууд нэмэгдээд байна уу яг юунаас болоод байна вэ? Энэ хүн амын өсөлттэй холбогдуулаад цагдаа хүчний байгууллагуудаа нэмэх шаардлагатай байгаад байна уу гэсэн ийм судалгаануудыг ер нь хийж ер нь Засгийн газарт ийм чиглэл өгөөд мөн Их Хурлаас ч гэсэн ажлын хэсэг гаргаад тэгээд судалж бүтцийн өөрчлөлттэй хамт хийх ёстой. Яг үнэндээ бол энэ орон тоо нэмэгдэж байгаа нэг шалтгаан бол энэ олон яам ч шүү. Яамд салбараар нь бий болгож байгаа байхгүй юу. Арван хэдхэн яамтай байсан, хорин хэдхэн яамтай.

Засгийн газар өөрөө энэ төрийн албаны тоог нэмэх гол үндсийг нь тавиад өгчхөж байна шүү дээ. Олон яамтай байгаа учраас. Салбар салбараар нь бий болгож байна шүү дээ. Энэ бол төсвийн энэ тэлэлттэй шууд уялдаатай байгаа. Тийм учраас ер нь нэг Их хурал шийдвэр гаргаад энэ бүтцийн өөрчлөлтийн Засгийн газрын бүтцийг өөрчлөлтгүйгээр баталж өгөх хэрэгтэй.

Дэд бүтцийн яам дөрөвхөн 4 яамыг нэгтгээд л болж л байсан шүү дээ. Дэд бүтцийн яам чинь 4, 5 яам одоо бараг тэр нөгөө цүнхтэй сайдуудтай яривал бараг 6, 7 яам болчихсон байгаа шүү дээ. Нэг яам, хуучин нэг яам хийж байсан ажил.

Тийм учраас энэ бүтцийн өөрчлөлттэй холбогдолтойгоор энэ төсвийн энэ тэлэлтийг зогсох ийм арга хэмжээ авахгүй болохгүй. Сая яах вэ Ерөнхийлөгчийн энэ хориг тавьсан энэ Их Хурал дээр бас ингээд зардлыг таная. Эхнээс нь бид нар ч бас ярьсан шүү дээ. Ер нь бол одоо ганцхан нүүрснээс хамааралтай эдийн засагтай байж төсвөө ингэж тэлээд байж болохгүй гэж. Тэгээд энэ сайн дохио болсон. Одоо ингэж хориг тавигдсанаараа дахиад бид нар ахиж Засгийн газар төсвийг ингэж 1, 2 дахин болгож оруулж ирэхгүй болчхож байгаа байхгүй юу. Энэ нэг талаасаа сайн дохио байсан.

Тэгэхээр энэ гишүүд маань ч гэлээ гэсэн сая бас ажлын хэсэгт ажиллаад ер нь энэ нэг төсвийн бүтэц энэ төсвийн тэлэлттэй холбогдолтой нэлээн сайн мэдээлэл авсан байна энэ сайн.

Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. 2, 3 зүйл байгаад байгаа юм.

Нэгдүгээрт энэ Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоол дээр 3 асуудал үүслээ гэж ингэж ойлгогдож байгаа.

Нэг нь гүйцээн боловсруулах чиглэл өгөгдчихсөн өчигдөр. Тэрнийг би Тэмүүлэн гишүүнийг, найруулга томьёоллынх нь асуудлыг бэлэн болгосон байх тэнд анхны төсөл яригдаад тэрэн дээр нь төсвөө хэлэлцсэний ар дээр энүүнийгээ нийцүүлж зохицуулалтынх нь асуудлыг шийдье гэдэг ийм юм яригдсан.

Хоёр дахь зүйл. Өчигдөр санал хураалтын явцад 2 асуудал орж ирсэн.

Нэгдүгээрт, тэр боловсролын салбарын санхүүжилтийн босгуудыг заагаад өгчихсөн. ДНБ-ий тэдээс доошгүй төсвийн тэдээс доошгүй гээд. Тэгэхээр энэ дээр манай энэ Сангийн яам ер нь ямар тооцоолол судалгаатай байгаад байгаа юм бэ? Энүүгээр бариад явбал наадах чинь өөрөө өөрчлөгдөж байдаг өсөн нэмэгдэж байдаг үндсэн үзүүлэлттэй чинь уяад хувь заачихсан. Тэгээд энэ нь ер нь ямархуу байдлаар хангагдах юм юу гэж тооцоод байна вэ? Энийг хэдүүлээ ер нь нэг зөв шийдлийг нь олж гаргах ёстой юу гэдэг нэг ийм асуулт байна. Энэ дээр нэг хариу авмаар байна.

Хоёр дахь зүйл тэр Засгийн газарт өгч чиглэлийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг бид нар улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдээд байгаа энэ барилга байгууламжуудын төсөвт магадлал хийж, аудит хийлгэж 2025 оны 1 дүгээр улиралд оруулж ирэх чиглэлийг Засгийн газартаа өгсөн юм. Бид нар энэ үйл явцыг энэ ковидтой холбогдуулаад нэг авч хэрэгжүүлсэн. Тэр нь ерөөсөө энэ төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл арга хэмжээнүүдийн тэр магадлалыг аудит хийлгэж 2023 оны төсөвт нэг шинэчилж авч хэрэгжүүлсэн. Яг ийм тохиолдлоор явсан зүйлүүд өнөөдөр зарим төсөл арга хэмжээ үргэлжилж байх ёстой.

2025 оны төсөвт суусан бусад арга хэмжээнүүд нь бол дандаа шинэ зураг төсвөөрөө явж байгаа ийм зүйл гэж. Гэтэл энэнд хамрагдаж орж ирээгүй нь тэр төсөвт өртөг нь нэмэгдчихээд магадлал нь хийгдчихээд тэгээд аудитлагдаж

чадаагүй нэлээн олон төсөл арга хэмжээнүүд өсөлт нь энэ төсөв рүү орж ирж чадахгүй хүлээгдээд байгаад байгаа юм аа.

Тэгээд энийгээ зөв зохицуулах үүднээс ийм заалт орсон. Гэтэл өчигдөр чуулган дээр гишүүний гаргасан саналаар энэ орхигдсон төсөл арга хэмжээнүүдийг биш 2025 оны төсөвт суучихсан арга хэмжээнүүдийг аудитлахаар ингээд өөрчлөн найруулчихсан. Тэгээд бид нар энэ үндсэн санаа.

**Ц.Даваасүрэн:** Ингээд эхний энэ зарчмын зөрүүтэй саналууд хураагдсантай холбогдолтойгоор нийцүүлж зохицуулалт хийсэн үү гээд байгаа нь та Тэмүүлэн гишүүнээс асуугаад байна уу? Тэр нь бэлэн болчихсон юм уу? Тэр бэлэн болчихсон юм байна.

2 дахь асуудал дээр Сангийн яам хариулъя. Тэр ер нь бол яах вэ боловсролын зорилт дээр байдаг юм. Нийт төсвийн зарлагын 20 хувь хүргэнэ гэсэн тийм зорилттой юм. Тэр нэг Юнеско ч билүү, юу ч билээ, нэг НҮБ-ын ч билүү нэг ийм хөтөлбөрүүдтэй. Тэрэндээ болохоор төсвийн зардал нөгөө бусад орнуудын, хөгжингүй орнуудын жишиг 20 байдаг гэсэн нэг юм байдаг юм. Тэрийг л өчигдөр батлуулчихлаа. Тэгэхдээ манайд 20 хүртэл өдий байгаа юм байна лээ шүү дээ. Энэ дээр бодитой зүйл үү, энэ цаашдаа яах юм бэ гэдэг хариултыг Батжаргал гишүүн хүсээд байх шиг байна. 4 номерын микрофон. Сайд хаачихсан бэ?

**М.Санжаадорж:** Сангийн яам Санжаадорж. Батжаргал гишүүний асуултад хариулъя аа. Сая шинээр дахин өргөн барьсан хууль дээр нийт зарлага ДНБ-ий 35.2 хувийг эзэлж байгаа.

Төсвийн хүрээний мэдэгдлийн 2026-2027 оны төсөөллөөр бол 32.8 гээд буурчихсан байгаа. Тэгээд ирэх жилүүдэд ч гэсэн бид нар алдагдалгүй төсөв барих учраас ингээд нэлээн буугаад 30-аас бол доош ер нь 28 он гэхэд буучих ийм хандлага харагдаад байгаа юм. Урсгал зардал бүүр 20-оос доош хувь руу орж ирэх болов уу?

**Ц.Даваасүрэн:** Боловсролыг асуугаад байна шүү дээ?

**М.Санжаадорж:** Тийм. Тэгэхээр өөрөөр хэлбэл нийт 30 хувиа л бид нар 6 хувийг нь боловсролд зарцуулаад дахиад эрүүл мэнд дээр 6 хувь гэж байгаа, шинжлэх ухаан дээр 2 хувь гэж байгаа, гамшгаас хамгаалах дээр нэг хувь гэж байгаа, аюулгүй байдал дээр нэг хувь гэж байгаа.

Ингээд явчихлаар бодитоор бол хэрэгжих боломжгүй заалт болчихоод байгаа. Тэрийг хэрэгжүүлнэ гэвэл бусад салбар дээр мөнгө тавьж чадахгүй л болох юм байна лээ. Яг математик тооцооллоор төсвийн тооцооллоор төлөлтийн дагуу бол тийм боломж бол байхгүй болчихно.

**Ц.Даваасүрэн:** Тогтвортой хөгжлийн НҮБ-ын трэндэд нь байдаг байхгүй юу. Ер нь бол яах вэ ингээд бусад улс орон, хөгжингүй улс орнуудын боловсролын зардал нийт төсвийн зарлагын 20 хувь л байдаг юм байна лээ л дээ. Энэ асуудлыг хэрвээ одоо хүндрэлтэй гэж үзэж байгаа бол 3-ны 2-оор санал хураалгах уу хэдүүлээ? Тэгвэл Батжаргал гишүүн төлөвлөөд зарчмын зөрүүтэй санал хураалгаад ирье.

3 дахь асуудал нөгөө аудитын асуудал байгаа юм. Энэ чинь ер нь энэ хөрөнгө оруулалтын ажлуудын төсөв дээр 2013 онд нэг удаа хийсэн юм. Бас ийм асуудал үүсээд. Тэгээд дараа нь тэр Батжаргал даргын хэлээд байгааг бас 2022 онд билүү бид нар чинь. Үгүй 2023 оны төсөвт тусгасан санагдаад байна. Ингээд хийсэн боловч нөгөө барилгын салбарын ажиллах хүчний зардал нь энэ төсөвт тусаж байгаа чинь бол яг зах зээл дээр байгаагаас даруй 2, 3 дахин хямдхан байгаад байгаа байхгүй юу. Тэгээд өнгөрсөн хавар барилгын сайдын шийдвэр гаргаад зах зээлийн үнэд нь ойртуулсан байгаа, ойртуулсан байгаа.

Тийм учраас бид нар ер нь тэр энэ Улсын төсвийн хөрөнгөөр хийж байгаа ажлуудын төсвийн норм нормативыг өөрчилж шинэчлэхгүй бол зах зээлийн өртгөөс нь хямд байгаад байгаа нэг ийм юм байгаа.

Тийм учраас заавал тэр аудит хийлгэх магадлан хийлгэх ийм зайлшгүй шаардлага бол байгаа. Тэгэхээр Батжаргал гишүүний асуугаад байгаа өмнөх бид нар ингээд бүх хийгдэж байгаа ажил дээр гэсэн. Өчигдөр Үүрийнтуяа гишүүн болохоор зөвхөн 2025 оны төсөвт хийх ажил дээр болгочихлоо, ингээд хязгаарлалчхлаа гээд байна шүү дээ. Энэ дээр Сангийн яам ямар саналтай байгаа юм? 6 номерын микрофон.

**Ж.Дэлгэржаргал:** Сангийн яам Дэлгэржаргал, Үүрийнтуяа гишүүний санал болохлоор 2025 оны төсөвт одоо батлагдчихсан. Ялангуяа шилжих төслүүдийн хувьд түрүүн Батжаргал гишүүний хэлсэн 2023 онд бид нар үндэсний аудитын дүгнэлт гаргаад дүгнэлтийнх нь дагуу тавьсан өртгүүд байгаа. Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд бол шинэ магадлалтай.

Тэгэхээр Үүрийнтуяа гишүүний орсон заалтаар бол бид нар 2025 оны төсөвт батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийнхээ төсөвт өртөгтэй дахиж тэгэхдээ яг аудит гэж заагаагүй. Хөндлөнгийн хараат бус байгууллагаар хянуулаад дүгнэлтийг 2 дугаар улиралд багтаан танилцуулна.

Ахиад нөгөө бид нар Засгийн газар өргөн барихдаа аваагүй өртгийн нэмэгдлийг дахиж аудит хийх нь ахиад тусдаа заалт байгаа. Тэгэхээр ийм 2 асуудал орж ирсэн гэсэн үг.

**Ц.Даваасүрэн:** 6 номерын микрофон.

**Ж.Дэлгэржаргал:** Өчигдрийн орсон заалтаар 2025 оны төсөвт ингээд батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийг бид нар заавал дахиж хянуулах хэрэгтэй болж байгаа гэсэн үг. Аудитын дүгнэлт гарчихсан төслүүдийг ч хянуулна. Шинээр дутагдсан төслүүдийнхээ өртгийг ч хараат бус хууль хяналтын байгууллага шаардлагатай хэрвээ энийгээ оруулж ирэхгүй бол сонсгол хийнэ гэдэг ийм асуудал яригдсан. Тэгэхээр 2 асуудал яригдаад байгаа гэсэн үг 2 тусдаа.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүн тодруулъя.

**Ж.Батжаргал:** 2025 оны төсөвт туссан арга хэмжээнүүд магадлал нь хийгдээд аудитаар орчихсон нэг хэсэг бий. Шинээр зураг төсөв нь хийгдээд магадлалд орчихсон нэг хэсэг байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар тэр 2 байгууллага угаасаа манайх хийчихсэн гэдгээрээ ярина. Одоо хууль хяналтын байгууллагатай л ярих юм байвал байна. Тэгэхээр энэ нэг их тийм ач холбогдолтой

биш юм болчхоод байгаа байхгүй юу. Харин бид төсөв рүү орж ирээгүй юмаа аудиталъя гэдэг юм ярьсан байхгүй юу. Тэгж байж энэ нэг баахан хүлээгдчихээд байгаа удаширчхаад байгаа төсөл арга хэмжээнүүдийн явцыг урагшлуулъя гэдэг байдлаар томъёолсон юм. Гэтэл өчигдрийн зарчмын зөрөөтэй санал яг үндсэн томъёоллын өөрчлөхөөр оруулж ирээд санал хураачихсан нь аюул болчхоод байгаа юм. Тэрнээс тусдаа заалт байсан бол ямарваа нэгэн асуудал байхгүйгээр явчих бололцоо байсан юм аа.

Дээр нь тэр боловсролын юм бол 6 хувиас арван хэдэн хувиас доошгүй гээд хэлчихсэн. Хүртэл гэсэн боо хамаа алга. Бид өнөө эрмэлзлээрээ боловсролын салбараа хөгжлийн тэргүүлэх чиглэл гэж үзээд тэр рүүгээ дөхүүлнэ гээд явах бололцоо байгаа юм. Тийм учраас энэ улсын ДНБ-ий чинь өсөлт түүнтэй харьцаж байгаа энэ төсвийн чинь өөрийнх нь зардлын харьцаа тэрэн дотроо тодорхой тийм функтийг нь эзлэх салбаруудынхаа юмыг бодохоор энэ улс орны чинь хөгжил цаашаа хангагдаж явах юм уу үгүй юм уу гэдгийг ул суурьтай асуугаад энэ бол одоохондоо үнэхээрийн тийм төвөгтэй байна гэвэл боловсролын салбарын тэр хөгжлийн баримт бичигтэй байж байгаа үндсэн зорилтоороо бид бодлогоо авч яваад энийг 3-ны хоёрдож асуудлыг нь эргэж харах шаардлага байна гэж надад ийм санаа гуйгаад байгаа юм аа.

Тийм учраас ийм санал гаргаж байна.

Та зарчмын зөрүүтэй санал гаргаад хураалгачихъя. Гишүүдээ нэг зүйл дээр анхаараадхаач. Тэр Үүрийнтуяа гишүүний хураалгасан санал чинь болохоор 2025 оны төсөвт бидний баталж байгаа хөрөнгө оруулалтуудыг дахиж нягталъя гээд байгаа юм биш үү? Тэгэхээр тэр чинь бараг хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүд хэрэгжихгүй болно гэсэн үг байхгүй юу. Тэгээд бид нар ер нь энэ орж ирж байгаа энэ батлагдсан төсвүүдийг идэвхгүй болж байна гэсэн үг тийм үү? Тэгээд аудит хийсэнд нь идэвхгүй болж байна гэсэн үг. Тэгж бас болохгүй л дээ энэ чинь. Тийм тэр ч арай утгагүй л юм байна. Үгүй үгүй ер нь тэгээд одоо ингээд энэ батлагдсан энэ нөгөө баталгаажсан төсвүүдийг бүгдийг нь худлаа гэж бид нар үзэх чинь хэцүү шүү дээ энэ чинь.

Энийг хэдүүлээ хэрэгжүүлэх боломжийг хар аа. Манай Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараах тохиолдолд санал хураалт явуулж болно гэж байна.

42.2.3 Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн бол гэж.

Тэгэхээр би та нараар дахин санал хураалгах шаардлагатай юу гэж санал хураалт явуулах юм байна.

Тэгээд 3-ны 2 нь болно гэх юм бол энэ саналыг дахиад хураачхаж болох юм байна. Окэй гишүүд саяын Батжаргал гишүүний гаргасан. Ингэе Батжаргал гишүүний гаргасан горимын саналын дагуу тэр Мөнхтуяа гишүүний тэр боловсролын зорилттой холбогдолтой. Үгүй тэр чинь яг тусгай тоо байхгүй юм байна. Тухайн гишүүний гаргасан санал гэдгээр байдаг юм байна. Санал гаргасан тэр гишүүн гэж байгаа учраас болохгүй юм байна.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяагийн гаргасан боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэхтэй холбогдолтой боловсролын салбарын нийт төсөв зардлыг ДНБ-ий 6 хувиас багагүй эсвэл улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж өргөн барьж байх гэсэн саналыг хэрэгжүүлэх боломжгүй, үндэслэлгүй байгаа учраас энэ саналыг дахин хураая гэсэн горимын саналыг Батжаргал гишүүн гаргаж байгаа юм шүү дээ.

Тэгэхээр 3-ны 2-оор дахин хураах боломжтой гэж үзэх юм бол хурааж болох юм байна. Тэгвэл би Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Дахин хураалгая гэж байна шүү дээ тиймээ? Батжаргал гишүүний микрофоныг өгье тайлбар хийчих.

**Ж.Батжаргал:** Энэ төсвийн тэнцлийнх нь талаасаа ч тэр ер нь энэ салбаруудын тэнцвэртэй хөгжлийн талаасаа ч тэр энийг бид эргэж харахаас өөр аргагүй болчихоод байгаа юм. Доошгүй гээд хэлчхээд байгаа бид өнөөдөр төсвийн зарлагаа ДНБ-ийхээ 30 хэдэн хувиар хязгаарлалт хийгээд яваад байдаг. Гэтэл нэг салбар нь дангаараа тэдээс доошгүй гээд хэлчихээр зэрэг салбар хоорондын хөгжлийн баланс алдагдах гээд байгаа байхгүй юу энэ чинь. Тийм учраас энийг бид ярихаас өөр арга байхгүй. Гэхдээ дэлхийн тэр улс орнуудын чигийг баримтлаад энэ Монгол Улсад мөрдөгдөж байгаа хөгжлийн бодлогынхоо баримт бичиг энүүнийгээ бариад боловсролын салбартаа олгох санхүүжилтийнхээ хэмжээг нэмэгдүүлж явах тэр зарчим нь хэвээрээ гэсэн үг шүү дээ. Тэгээд энэ үүднээс нь би энийг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн 3-ны 2-оор дахин нэг ярилцаж хасах нь зүйтэй гэсэн л ийм л санал гаргаад байна л даа.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүний хэлээд байгаа энэ бид нарын гаргах гэж байгаа тогтоол чинь 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тогтоол байхгүй юу. Энэ заалт бол дунд хугацааны юм уу, урт хугацааны хөтөлбөрийн зорилт маягийн заалт байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас 2025 оны төсөвтэй холбогдуулан авах арга хэмжээнд зохисгүй байна. 2026 оны төсөв дээр яг энэ хэмжээгээр тусгах боломжгүй байна гэж үзсэн учраас энэ саналыг гаргаад байгаа юм.

Тэгэхээр Батжаргал гишүүний гаргасан саналын дагуу Мөнхтуяа гишүүний энэ саналыг дахин хураая гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Дахин санал хураалт явуулъя, дахин санал хураалт явуулъя, хүчингүй болгоё. Гишүүд анхаарч байгаарай. Дахиад нэг юу яах вэ нэг юу туршилтын санал хураалт хийж үзэх үү? Туршилтын санал хураалт.

Уг нь болохоор байна. Ингээд анхааралтай хэдүүлээ Батжаргал гишүүний гаргасан санал хураалтыг дахин явуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

18 гишүүн санал хураалтад оролцсон. 14 гишүүн дэмжиж 77.8 хувиар уг санал дэмжигдсэн. Батжаргал гишүүнийг протоколд дэмжсэнээр авлаа.

Ингээд Баясгалан гишүүнийг бас протоколд дэмжсэнээр авъя. Ингээд санал хураалт явуулъя.



Тийм хасах санал хураалт явуулна. Ингээд “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслөөс Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан саналыг хасах нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Батжаргал гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулна. Би та бүхэнд уншиж танилцуулъя.

Төсөлд дараах агуулгатай 4 дүгээр зүйл шинээр нэмэх боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоно тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т заалгасугай:

1/2026 оны төсвийн жилээс эхлэн Боловсролын салбарын төсвийн нийт зардлыг ДНБ-ий 6 хувиас багагүй эсвэл Улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж өргөн барих.

2/Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Мөнхтуяа гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 18 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж, 11.1 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн саналаа танилцуулъя. Нөгөө 2 дахь саналаа. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

**Ж.Батжаргал:** “Засгийн газарт чиглэл өгөх өгөх тухай” тогтоол дээр байж байгаа 1.3 дахь заалт бол яах аргагүй энэ хөрөнгө оруулалтын арга хэмжээ төсөл хөтөлбөрүүдийг үр дүнтэй урагшлуулах чиглэлээр томьёологдож орж ирсэн санаа байгаа юм аа. Үүн дээр Үүрийнтуяа гишүүн зарчмын зөрөөтэй санал гаргаад шинэчилж найруулсан нь 2025 оны төсөвт тусгагдчихсан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээнүүдийг дахин аудитлахаар оруулж ирж байгаа нь бид нарын үндсэн барьж боловсруулсан өнөө үзэл санаатай зөрчхөөд болж өгөхгүй байна. Тийм зөрчилдөөд байна. Тийм учраас энийг бас өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн 3-ны 2-оор нь дахин санал хураалгаад тэгээд энийг өөрчлөхгүй бол яг үзэл санаа зөрчигдчихөөд болж өгөхгүй байна. Үзэл баримтлал.

**Ц.Даваасүрэн:** Ингээд Батжаргал гишүүний гаргасан горимын саналын дагуу Үүрийнтуяа гишүүний 2 дугаар хэлэлцүүлэг дээр гаргасан саналыг дахин хураалгая гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

18-аас 14 гишүүн дэмжиж, 77.8 хувиар дахин санал хураалт явуулах санал дэмжигдлээ. Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авлаа. Баясгалан гишүүнийг дэмжсэнээр протоколд авлаа. Ингээд санал хураалт явуулъя.

Одоо би Үүрийнтуяа гишүүний саналыг одоо хураалгах гэж байна. Мөнхсоёл гишүүн ээ. Ингээд гишүүд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын 1.3-д 2025 оны улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтаан Улсын Их Хуралд танилцуулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа.

Энэ саналаар дахин санал хураалт явуулъя. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

18 гишүүн санал хураалтад оролцож нэг ч гишүүн дэмжээгүй байна.

Энэ санал дэмжигдсэнгүй ээ.

Нэгдсэн хуралдаанаар хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж хуулийн төслийн холбогдох зүйл хэсэг заалттай уялдуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн асуудлаар санал хураалт явуулж эхэлье.

Зарчмын зөрүүтэй санал шүү. Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалтын шаардлага хангасан барилгыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс “лизингийн нөхцөлөөр өөрийн өмчлөлд бүрэн шилжүүлж авах”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням уу? Өөр хэн байгаа юм? Г.Тэмүүлэн нарын санал.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

19 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 63.2 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Батжаргал гишүүн, Баясгалан гишүүн, Ганзориг гишүүн, Мөнхсоёл гишүүн, Батлут гишүүн нарыг дэмжсэнээр авъя аа. Ингээд уг санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Байж байгаарай гишүүд ээ.

Өнөөдрийн хуралдаан дууссан тул гишүүдэд баярлалаа.

11.53 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА